Сум хөгжүүлэх сан	15,861.9	68,880.6	53,018.70	55.0%
<u>Замд яваа мөнгөн хөрөнгө</u>				
<u>Хадгаламж</u>				
Дүн	40,708.40	125,265.10	84,556.70	100%

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Оны эцэс дэх нийт мөнгөн хөрөнгийн 43.9 хувийг орон нутгийн ерөнхий орлого, 55.0 хувийг сум хөгжүүлэх сангийн, 1.1 хувийг ОНХС-ийн харилцах дансны үлдэгдэл эзэлж байна.

Орон нутгийн ерөнхий орлогын данс оны эцэст 54984.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэйгээс 3859.2 мянган төгрөг нь оны эхний зарцуулаагүй үлдэгдэл, 29996.2 мянган төгрөг нь оны эцэс төсөвт байгууллагуудаас төвлөрүүлсэн төсвийн хэмнэлт, 21128.6 мянган төгрөг нь төлөвлөгөөнөөс давсан татварын орлогын үлдэгдэл байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 227044.7 мянга, эцсийн үлдэгдэл 195837.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 31206.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	1,547.1	1,433.0	(114.1)
Байгууллагаас авах авлага	40,000.0	59,950.0	19,950.0
Хувь хүмүүсээс авах авлага	6,400.0	5,000.0	(1,400.0)
Зээлийн авлага	179,097.6	129,454.9	(49,642.7)
Дүн	227,044.7	195,837.9	(31,206.8)

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Оны эцсийн нийт авлагын 66.1 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага, 28.1 хувийг ОНХС-ийн байгууллагаас авах авлага, 5.1 хувийг сургуулийн байгууллагаас авах авлага, 0.7 хувийг цэцэрлэгийн ажиллагсадтай холбоотой авлага эзэлж байна.

Хүснэгт 3. Байгууллагын авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

№	Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс:			Зээлийн авлага	Дүнд эзлэх хувь
				Ажиллагсадтай холбоотой	Байгууллагаас авах	Хувь хүмүүсээс авах		
1	ЕБС	117.8	9,953.7	3.7	9,950.0	-	-	5.1
2	Цэцэрлэг	1,429.3	1,429.3	1,429.3	-	-	-	0.7
3	ОНХС	46,400.0	55,000.0	-	50,000.0	5,000.0	-	28.1
4	СХС	176,097.6	129,454.9	-	-	-	129,454.9	66.1
	ДҮН	224,044.7	195,837.9	1,433.0	59,950.0	5,000.0	129,454.9	100

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 249904.2 мянган төгрөг байснаас тайлант онд 3977.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст бараа материалын үлдэгдэл 253881.6 мянган төгрөг болсон байна.

Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Эм боох материал	240.0	1,513.1	1,273.1
Бэлэн бүтээгдэхүүн	0.0	4,400.0	4,400.0
Бичиг хэргийн материал	13,434.4	12,515.7	(918.7)
Аж ахуйн материал	173,083.1	171,901.6	(1,181.5)
Сэлбэг хэрэгсэл	0.0	211.9	211.9
Барилгын засварын материал	0.0	12.0	12.0
Түлш, шатах тослох материал	74.9	0.0	(74.9)
Хүнсний материал	3,637.2	1,300.8	(2,336.4)
Бусад хангамжийн материал	46,103.6	48,695.5	2,591.9
Мал амьтад	13,331.0	13,331.0	0.0
Дүн	249,904.2	253,881.6	3,977.4

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсөвт байгууллагууд 173464.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 7924.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, 150210.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулжээ.

Хүснэгт 5. Байгууллагын бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн			БҮГД	Хасагдсан		БҮГД	Эцсийн үлдэгдэл
			Төсвийн хөрөнгөөр	Хандиваар	Бусад		Худалдсан, зарцуулсан	Бусад		
1	ИТХурал	2,481.0	6,529.6	460.0		6,989.6	5,750.6	5,750.6	3,720.0	
2	ЗДТГазар	60,050.0	33,611.5			33,611.5	32,592.9	32,592.9	61,068.6	
3	Сургууль	128,492.8	91,829.5	7,464.5		99,294.0	74,553.7	27,415.3	101,969.0	
4	Цэцэрлэг	36,786.6	34,599.3		214.2	34,813.5	35,795.3		35,795.3	
5	Соёл	22,093.8	2,494.5			2,494.5	1,517.9		1,517.9	
6	ЭМТөв					-			-	
7	ОНХСан		4,400.0			4,400.0			4,400.0	
ДҮН		249,904.2	173,464.4	7,924.5	214.2	181,603.1	150,210.4	27,415.3	177,625.7	253,881.6

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4101820.1 мянга, эцсийн үлдэгдэл 4014981.2 мянган төгрөг болж, 86838.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	2,254,038.9	2,090,019.2	(164,019.7)
Тээврийн хэрэгсэл	197,264.8	182,864.8	(14,400.0)
Машин тоног төхөөрөмж	519,057.4	557,124.1	38,066.7
Тавилга эд хогшил	381,038.4	391,308.0	10,269.6
Зам гүүрийн барилга байгууламж	420,474.3	438,474.3	18,000.0
Түүх, соёлын дурсгалт зүйлс	458.9	458.9	-
Номын фонд	45,063.4	49,997.0	4,933.6
Бусад үндсэн хөрөнгө	218,975.0	240,286.0	21,311.0
Программ хангамж	2,439.0	1,439.0	(1,000.0)
Бусад биет бус хөрөнгө	63,010.0	63,010.0	-
Дүн	4,101,820.1	4,014,981.2	(86,838.9)

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 32671.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, хандиваар 8712.2 мянга, бусад байгууллагаас 77773.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг

шилжүүлэн авч, 3 төсөвт байгууллага нийт 200648.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, цэцэрлэг 5346.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэн байна.

Хүснэгт №7. Байгууллагын үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн			БҮГД	Хасагдсан		БҮГД	Эцсийн үлдэгдэл
			Худалдан авсан	Хандиваар	Шилжүүлэн авсан		Акталсан	Шилжүүлсэн		
1	ИТХурал	9,214.8	1,700.0	-	-	1,700.0	-	-	-	10,914.8
2	ЗДТГазар	1,699,030.8	-	-	41,705.4	41,705.4	43,522.4	-	43,522.4	1,697,213.7
3	Сургууль	1,255,286.3	13,461.0	8,712.2	24,845.6	47,018.8	154,878.5	-	154,878.5	1,147,426.7
4	Цэцэрлэг	1,073,408.2	13,686.0	-	11,222.2	24,908.2	2,248.0	5,346.4	7,594.4	1,090,722.0
5	Соёл	64,880.0	3,824.0	-	-	3,824.0	-	-	-	68,704.0
ДҮН		4,101,820.1	32,671.0	8,712.2	77,773.2	119,156.4	200,648.9	5,346.4	205,995.3	4,014,981.2

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрт урт хугацаат зээл байхгүй, богино хугацаат өр төлбөрийн эхний үлдэгдэл сумын цэцэрлэгийн ажилчидтай холбоотой 66.1 мянган төгрөгийн өглөг тайлант онд барагдаагүй үлдэгдлээр байна.

Хүснэгт №8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр дүн	66.1	66.1	0
Ажилчидтай холбогдсон өглөг	66.1	66.1	0
Урт хугацаат өр төлбөр дүн	0.0	0.0	0
Дүн	66.1	66.1	0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3459738.8 мянга, эцсийн үлдэгдэл 3266945.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 192793.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №9. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,444,813.9	1,444,813.9	-	44.2
Хуримтлагдсан үр дүн	1,491,183.3	1,490,204.9	(978.4)	45.6
Өмнөх үеийн үр дүн	1,437,104.7	1,682,998.1	245,893.4	
Тайлант үеийн үр дүн	54,078.6	(192,793.2)	(246,871.8)	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	523,741.6	331,926.9	(191,814.7)	10.2
Дүн	3,459,738.8	3,266,945.7	(192,793.1)	100

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны өмнөх оны үлдэгдэл 192793.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд үндсэн хөрөнгө акталсантай холбоотой байна.

3.5.10 Орлогын данс

Богд сумын ИТХ-ын хуралдааны 2019.12.18-ний өдрийн хуралдааны 16/19 дүгээр тогтоолоор Богд сумын Засаг дарга тайлант онд улсын төсөвт 4560.0 мянга, аймгийн төсөвт 125080.0 мянга, нийт 129730.0 мянган төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр төлөвлөгөөг 110.3 хувиар биелүүлснээс улсын төсөвт төвлөрөх татварын

орлого 657.9 мянган төгрөгөөр тасарч, аймгийн төсөвт төвлөрөх татварын орлого 14036.0 мянган төгрөгөөр давж биелсэн байна.

Хүснэгт №10. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А. Улсын төсөв	4,650.0	3,992.1	(657.9)	85.9
1. ААНБ-ын орлогын татвар	2,500.0	1,976.1	(523.9)	79.0
2. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,200.0	600.0	(600.0)	50.0
3. Агаарын бохирдол /авто/	950.0	1,416.0	466.0	149.1
В. Аймгийн төсөв /712/	125,080.0	139,116.0	14,036.0	111.2
1. ЦТХА орлого /Суутган -1/	108,000.0	123,271.7	15,271.7	114.1
2. АТӨЯХ-ийн татвар	13,300.0	14,514.7	1,214.7	109.1
3. ҮХЭХ-ийн татвар	1,200.0	1,136.5	(63.5)	94.7
4. Газрын төлбөр	2,580.0	193.1	(2,386.9)	7.5
Нийт дүн	129,730.0	143,108.1	13,378.1	110.3

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн татварын орлогын мэдээ

Улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогоос аж ахуйн нэгж байгууллагын орлогын болон нэмэгдсэн өртгийн албан татварыг биелүүлээгүйгээс татварын орлогын төлөвлөгөөг 14.1 хувиар тасалсан бол аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлого 111.2 хувиар биелэхэд цалингийн суутган, АТӨЯХ-ийн татвар давж биелсэн нь голлох нөлөө үзүүлжээ.

Сумын ИТХ-ын 2019.12.18-ний өдрийн хуралдааны 16/19 дүгээр тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 65680.0 мянга, хүү торгуулийн орлогыг 4500.0 мянга, нийт 70180.0 мянган төгрөгөөр баталсныг сумын ИТХ-ын 2020.09.23-ний өдрийн хуралдааны 17/02 дугаар тогтоолоор сумын 2020 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулж, агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийг 10000.0 мянга, газрын дуудлага худалдааны орлогыг 1000.0 мянган төгрөгийг хасаж тодотгож, сумын нийт төсвийг 59180.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №11. Сумын төсөвт төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1. Татварын орлого	54,680	75,436	20,756	138.0
1.1. ИОТХ	5,000.00	24,877.10	19,877.10	497.54
1.2. Хадгаламжийн хүүгийн орлого	30,000.00	31,233.00	1,233.00	104.11
1.3. ҮХЭХ борлуулсаны татвар	0.00	1,950.00	1,950.00	#DIV/0!
1.3. Бууны татвар	2,460.00	1,770.00	-690.00	71.95
1.4. Улсын тэмдэгтийн хураамж	2,500.00	1,741.10	-758.90	69.64
1.5. Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	9,000.00	9075	75.00	100.83
1.6. Ургамал ашигласны төлбөр	0.00	200	200.00	0.00
1.7. Түгээмэл тархацтай АМНАТ	2,000.00	750	-1,250.00	37.50
1.8. Агнуурын нөөц ашигласны	2,000.00	1718.5	-281.50	85.93
1.9. Газрын төлбөр	1720	2121.2	401.20	123.33
2. Татварын бус орлого	4,500	5,843	1,343	129.84
2.1. Хүү торгуулийн орлого	4500	5843	1,343.00	129.84
Нийт дүн	59,180.00	81,278.90	22,098.90	137.34

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн мэдээ

Сумын татварын орлогыг 137.3 хувиар биелүүлсэн нь тайлант онд ИТОХ-ын төлөвлөгөөг 15530.4 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн нь "Эрдэнэс-тавантолгой" ХК-ийн 2019 оны ногдол ашгийг иргэдийн дансанд төвлөрүүлсний хувь хүний орлогын албан татварыг сумын төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой ба төлөвлөөгүй үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараар 1950.0 мянган төгрөг оржээ.

Сумын ИТХ-ын 2019.12.18-ний өдрийн хуралдааны 16/19 дүгээр тогтоолоор сумын ЗДТГ, ерөнхий боловсролын сургуулийн өөрийн орлогыг тус бүр 1000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн ба өөрийн орлогоор ЗДТГ 984.5 мянга, сургууль 1119.9 мянга, нийт 2104.4 мянган төгрөгийг оруулсан байна.

Дээрх тогтоолоор сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн орлогоор тайлант онд 81628.0 мянган төгрөгийг оруулахаар баталж, гүйцэтгэлээр 71755.1 мянган төгрөгийг оруулж, төлөвлөгөөг 87.9 хувиар биелүүлсэн байна.

3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 9 хөтөлбөрт зориулан 2189453.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 2028752.1 мянган төгрөгийг зарцуулснаас 1969819.8 мянган төгрөгийг урсгал зардалд, 58932.3 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба аймгийн ИТХТ-ын 2019.11.29-ний өдрийн 11/09 дүгээр тогтоолоор нийт 2276723.6 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	116,157.50	77,887.90	-38,269.60
Засаг даргын Тамгын газар	364,487.00	368,834.30	4,347.30
Сургууль	1,145,344.80	1,150,943.80	5,599.00
Цэцэрлэг	468,378.00	373,913.10	-94,464.90
Соёлын төв	169,383.60	132,907.10	-36,476.50
Сум хөгжүүлэх сан		96,628.00	96,628.00
Орон нутгийн хөгжлийн сан		75,609.40	75,609.40
Нийт дүн	2,263,750.91	2,276,723.60	12,972.69

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2019.12.18-ний өдрийн 16/19 дүгээр тогтоолоор анх баталсан 2276723.6 мянган төгрөгийг сумын ИТХ-ын хуралдааны 2020.09.23-ний өдрийн 17/02 дугаар тогтоолоор 20962.0 мянган төгрөгөөр бууруулсан ба ЕБС, Цэцэрлэгийн төсвийг аймгийн Засаг даргын 2020.10.27-ний өдрийн А/770 дугаар захирамжаар 29637.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2020.12.31-ний өдрийн А/850 дугаар захирамжаар 95944.9 мянган төгрөгөөр бууруулснаар сумын нийт төсөв 2189453.8 мянган төгрөг болжээ.

Нийт баталсан зардлын 1290532.5 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 69190.5 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 650583.2 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 58180.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн төсвөөс, 83628.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 36339.6 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг бүрэн авч, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг 11605.7 мянган төгрөгийн

санхүүжилт дутуу авч, оны эцэст зардлын хэмнэлтээс 29996.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт, 40560.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 12. Байгууллагуудын батлагдсан төсөв, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Улсын төсөвт төвлөрүүлсэн	ОН-ын төсөвт төвлөрүүлсэн
Засаг даргын Тамгын газар	376,134.30	360,887.92	15,246.38	95.9		15230.9
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	78,715.90	74,316.38	4,399.52	94.4		4399.5
Ерөнхий боловсролын сургууль	1,118,464.90	1,081,702.25	36,762.65	96.7	36525.5	357.0
Цэцэрлэг	315,313.10	310,172.34	5,140.76	98.4	4034.6	1106.2
Соёлын төв	132,907.10	124,004.50	8,902.60	93.3		8902.6
Орон нутгийн хөгжлийн сан	71,290.50	58,932.28	12,358.22	82.7		0
Сум хөгжүүлэх сан	96,628.00	18,736.40	77,891.60	19.4		0
Нийт дүн	2,189,453.80	2,028,752.06	160,701.74	92.7	40560.1	29996.2

Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Богд сумын байгууллагуудын 2020 оны санхүүгийн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2028752.1 мянган төгрөг буюу 92.7 хувьтай байгаа нь ОНХС-ийн төлөвлөсөн зардлыг 12358.2 мянга, Сум хөгжүүлэх сангийн төлөвлөсөн зардлыг 77891.6 мянга төгрөгөөр дутуу олгосон, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 26588.7 мянга, нормативт зардлыг 17807.9 мянган төгрөгөөр хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,189,453.8	2,028,752.8	160,701.7	92.7
70105 ОН-ын өөрөө удирдах ёсны байгууллага	78,715.90	74,316.30	4,399.60	94.4
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	63,553.80	61,778.20	1,775.60	97.2
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	537.00	522.00	15.00	97.2
80825 Багийн ИНХ-ын даргын урамшуулал	14,625.10	12,016.10	2,609.00	82.2
70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	376,134.30	360,887.90	15,246.40	95.9
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	258,473.00	245,944.50	12,528.50	95.2
80106 Баг, хорооны ҮАЗардал	78,493.30	75,775.40	2,717.90	96.5
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	19,168.00	19,168.00	-	100.0
81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	11,000.00	11,000.00	-	100.0
81701 Байгаль орчин хамгаалах зардал	-	-	-	#DIV/0!
82212 Хур хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах зардал	9,000.00	9,000.00	-	100.0
70503 Орон нутгийн зорилтот ХОруулалт	71,290.50	58,932.20	12,358.30	82.7
80904 Нийгмийн зориулалттай барилга	71,290.50	58,932.20	12,358.30	82.7
71702 Соёл урлаг	132,907.10	124,004.50	8,902.60	93.3
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	132,607.10	123,704.50	8,902.60	93.3
80802 Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	300.00	300.00	-	100.0
71801 Сургуулийн өмнөх боловсрол	315,313.10	310,172.40	5,140.70	98.4
80109 ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	33,990.60	32,884.40	1,106.20	96.7
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	151.50	151.50	-	100.0
81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол	21,254.00	21,253.50	0.50	100.0
81831 Ээлжийн бүлэг	9,439.30	9,417.70	21.60	99.8
81832 Нүүдлийн бүлэг	10,263.60	10,263.60	-	100.0
81833 Явуулын багшийн үйлчилгээ	1,150.90	1,147.00	3.90	99.7
81834 Боловсролын стандарт, сургалт	204,372.20	202,968.50	1,403.70	99.3
81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	34,691.00	32,086.20	2,604.80	92.5
71802 Ерөнхий боловсрол	1,118,464.90	1,081,701.10	36,763.80	96.7
80109 ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	108,254.90	107,897.90	357.00	99.7
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,587.30	1,587.30	-	100.0
81801 үдийн цай хөтөлбөр	33,798.10	16,583.70	17,214.40	49.1
81806 Дотуур байрны үйлчилгээ	114,905.80	96,510.00	18,395.80	84.0
81834 Боловсролын стандарт, сургалт	640,529.60	640,027.70	501.90	99.9

81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	209,352.10	209,057.50	294.60	99.9
71806 Насан туршийн болон албан бус боловсрол	10,037.10	10,037.00	0.10	100.0
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	10,037.10	10,037.00	0.10	100.0
72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	96,628.00	18,736.40	77,891.60	19.4
82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	96,628.00	18,736.40	77,891.60	19.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 91301.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт өгснөөс бараа үйлчилгээний зардалд 15993.8 мянган төгрөг зарцуулж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад 12593.5 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 62708.6 мянган төгрөгийг олгож, сумын ЗДТГ санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийн 0.9 мянга, Соёлын төв 4.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 13. Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зарлага, төвлөрүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ЗДТГ	Соёлын төв	ЕБС	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	14,332.20	1,666.70	75,302.10	91,301.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө				0.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,332.20		75,302.10	89,634.30
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1666.7		1,666.70
НИЙТ ЗАРЛАГА	14,331.30	1,662.50	75,302.10	91,295.90
Бараа, ажил үйлчилгээний зардал	14,331.30	1,662.50		15,993.80
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж			62708.6	62,708.60
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг			12,593.50	12,593.50
Төсөвт төвлөрүүлсэн	0.90	4.20	0.00	5.10

Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 146 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Хүснэгт 14. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Хоцроосон мэдээлэл
1	Бүтэн жил	14	14	9	5	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл, улсын төсөв болон ОН-ийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө
2	Хагас жил	3	3	3	0	
3	Улирал бүр	2	8	8	0	
4	Сар бүр	5	60	58	2	1, 3-р сарын ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл,
5	Тухай бүр	6	72	68	4	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг
Нийт		30	157	146	11	

Эх сурвалж. Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайланд итгэл үзүүлж, аудит хийгээгүй байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Богд сумын Засаг даргын үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдэл өмнөх оны аудитлагдсан тайлангаас 5631448.8 мянган төгрөгөөр зөрүүтэй, нэмэлт санхүүжилтийн тайлангийн зардлыг 229.7 мянган төгрөгөөр зөрүүтэй байсан зөрчлийг аудитын явцад залруулсан ба цаашид Засаг даргын нэгтгэсэн тайлангийн эхний үлдэгдлийг үнэн зөв тайлагнаж, төрийн аудитын байгууллагад үнэн зөв, бүрэн илэрхийлсэн санхүүгийн тайланг ирүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Сумын цэцэрлэг бараа материалын тодруулга тайланд худалдан авсан бараа материалыг 140.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн алдааг Сангийн яамны Э-тайланд залруулав.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн эхний, эцсийн үлдэгдлийг аудитлагдсан санхүүгийн тайлантай тулган шалгахад нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын аудитлагдсан санхүүгийн тайлангаар нэгтгээгүй, Э-тайланд орлого, зардлыг бөөн дүнгээр оруулсан, дансны ангилал зөрүүтэй оруулсан зэргээс шалтгаалж, аудитын явцад 173705.7 мянган төгрөгийн алдаа илэрснээс санхүүгийн байдлын тайланд 41549.5 мянга, үр дүнгийн тайланд 16258.2 мянга, мөнгөн гүйлгээний тайланд 6362.8 мянга, төсвийн гүйцэтгэлийн тайланд 58593.8 мянга, нэмэлт санхүүжилтийн тайланд 50801.4 мянга, бараа материалын тодруулга тайланд 140.0 мянган төгрөгийн алдааг залруулав.

**Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

№	Байгууллагын нэр	Санхүүгийн байдлын тайлан	Үр дүнгийн тайлан	Мөнгөн гүйлгээний тайлан	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Нэмэлт санхүүжилтийн тайлан	Бараа материалын тодруулга	Дүн
1	Засаг даргын Тамгын газар	41549.5	13,685.2	824.8		5,945.5		62,005.0
2	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал		1,815.9	1,700.0	11,211.4	500.0		15,227.3
3	Ерөнхий боловсролын сургууль					37,532.0		37,532.0
4	Цэцэрлэг		380.6		23,230.6	4,267.4	140.0	28,018.6
5	Соёлын төв		376.5	3,838.0	19,639.9	2,556.5		26,410.9
6	Сум хөгжүүлэх сан				3,111.9			3,111.9
7	Орон нутгийн хөгжлийн сан				1,400.0			1,400.0
	Дүн	41,549.5	16,258.2	6,362.8	58,593.8	50,801.4	140.0	173,705.7

Дээрх алдааны дийлэнх хувь нь өмнөх оны орлого, зардлыг зөрүүтэй оруулсан, зардлын ангиллыг буруу илэрхийлсэн байснаас гадна төсвийн гүйцэтгэлийн тайланд байгууллагын ажиллагсдын болон сурагчдын тоог аудитын тайлангаас зөрүүтэй оруулсан алдаа гарсныг аудитын явцад Э-тайлангийн тоогоор залруулав.

Төвлөрүүлэн захирагчид 190875.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 3 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 5 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 7 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллага аудитад хамрагдаж, сумын ИТХ-д итгэл үзүүлсэн байна.

№	Байгууллагын нэр	Аудит хийсэн байгууллагын нэр	Дүгнэлтийн хэлбэр
1	Засаг даргын Тамгын газар	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар	Зөрчилгүй
2	Ерөнхий боловсролын сургууль		Зөрчилгүй
3	Цэцэрлэг	"Глобал капитал" ХХК	Зөрчилгүй
4	Иргэдийн төлөөлөгчийн хурал	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар	Итгэл үзүүлсэн
5	Соёлын төв		Түүвэрт хамрагдсан
6	Орон нутгийн хөгжлийн сан		Түүвэрт хамрагдсан
7	Сум хөгжүүлэх сан		Түүвэрт хамрагдсан

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 45856.2 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчил илрүүлснээс 1813.2 төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 41500.0 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага өгч, 2543.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг хүргүүлжээ.

Үзүүлэлт	ЗДТГ	Цэцэрлэг	Ерөнхий боловсролын сургууль	Сум хөгжүүлэх сан	Дүн
Төлбөрийн акт	тоо	1	2		3
	дүн	174.8	1638.4		1813.2
Албан шаардлага	тоо	2			2
	дүн	41500			41500
Зөвлөмж	тоо	1	1	1	1
	дүн	2543.0	0	0	0
Залруулга	тоо				0
	дүн				0
Нийт алдаа зөрчил	тоо	4	3	1	1
	дүн	44217.8	1638.4	0	0

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар Э-тайлангийн эхний үлдэгдэл нь санхүүгийн тайлан гаргаж байгаа Acolous программын эхний үлдэгдэлтэй тохирч байгаа эсэхийг тулган баталгаажуулсан эсэхийг шалгах шаардлагатай байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

3.1.1. **Илрүүлэлт:** Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайлангийн орлого, зарлагын төрлийг санхүүгийн тайлангаас 173705.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, Хэмжилт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 55 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

3.1.2. **Эрсдэл:** Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн материаллаг хэмжээний алдаа зөрчлийн дүн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хүлээн зөвшөөрөгдөх материаллаг байдлаас хэтэрсэн байх.

3.1.3 **Өгсөн зөвлөмж:** Сумын төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн үнэн зөв гаргасан байдал, аудитлагдсан санхүүгийн тайланг Сангийн яамны Э-тайланд орлого, зарлагыг данс бүрээр тайлагнаж байгаад тавих санхүүгийн албаны даргын хяналтыг сайжруулах.

3.1.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

3.2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

3.2.1. **Илрүүлэлт:** Сум хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан 4 зээлдэгч 17030.0 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн орлогыг төлөөгүй хугацаа хэтрүүлж, оны эцэст хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байхад хяналт тавьж, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 4.7 дахь Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө" заалтыг зөрчсөн байна.

3.2.2 **Эрсдэл:** Сангийн хөрөнгөөс олгосон зээл гэрээнд заасан хугацаанд төлөгдөхгүй сан хохирох, дараагийн зээлдэгч сангаас зээл авах боломжгүй болох.

3.2.3 **Өгсөн зөвлөмж:** Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс хөнгөлөлттэй зээл авч хугацаандаа төлөөгүй 4 зээлдэгчийн 17030.0 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүг 2021 оны 06 дугаар сарын 25-ны дотор төлүүлэх арга хэмжээ авч, заасан хугацаанд төлөөгүй иргэдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх.

3.2.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

3.3. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

3.2.2 **Илрүүлэлт:** Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шилэн дансны цахим хуудаст тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 146 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтална" гэснийг зөрчсөн байна.

3.2.2 **Эрсдэл:** Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо бүрдүүлэхгүй байх.

3.2.3 **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах.

3.2.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 06 дугаар сарын 25-ний дотор нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн: АХЛАХ АУДИТОР		Б.ДОЛЖМАА 2021.03.25
Анхан шатанд хянасан: АУДИТЫН МЕНЕЖЕР		А.ЦЭЭНЯМ 2021.03.25
Хоёр дахь шатанд хянасан: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Б.МӨНХБАТ 2021.03.25

5. Хавсралт 1. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Богд сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код:
2021.03.25			БНА-2021/19/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Богд сумын Засаг дарга		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1		2	3	4	5
1.Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлан					
1	Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд орлого, зарлагын төрлийг санхүүгийн тайлангаас 173705.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.	173705.7	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Д.Өлзийбаяр, Д.Буянхишиг
2	Сумын цэцэрлэг бараа материалын тодруулга тайланд худалдан авсан бараа материалыг 140.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.	140.0	Санхүүгийн тайланд залруулсан.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Д.Өлзийбаяр, Д.Буянхишиг
3	Сум хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан 4 зээлдэгч 17030.0 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн орлогыг төлөөгүй хугацаа хэтрүүлж, оны эцэст хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байхад хяналт тавьж, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлээгүй байна.	17030.0	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Д.Өлзийбаяр, Д.Буянхишиг
4	Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шилэн дансны хуудаст 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	0	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Д.Өлзийбаяр, Д.Буянхишиг
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлангийн алдааны дүн		190875.7			
Харьяа төсвийн байгууллагуудын дүн					
Засаг даргын Тамгын газар					
1	Орон нутгийн өмчийн 2019 оны үзлэг тооллогоор дутагдсан 41500.0 мянган төгрөгийн хөрөнгийн эзэн холбогдогчийг тогтоож хуулийн байгууллагаар эцсийн шийдвэр гаргуулан байгууллагыг хохиролгүй болгох тухай Аймгийн Засаг даргын 2020 оны А/101 тоот захирамжийг төсвийн шууд захирагч хэрэгжүүлж ажиллаагүй байна.	41500.0	Албан шаардлага өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Б.Бурмаа, Ц.Ган-Өлзий
2	Тайлант хугацаанд ажиллагсдын захиалсан "Өнөөгийн - Баянхонгор" сонины үнэнд 174.8 мянган төгрөгийг ном хэвлэлийн зардлаас шилжүүлсэн байна.	174.8	Төлбөрийн акт тогтоосон.	Дарга, нягтлан бодогч	Б.Бурмаа, Ц.Ган-Өлзий
3	Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нийт 151 мэдээлэл оруулахаас 217019.8 мянган төгрөгийн 43 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан бол 780577.0 мянган төгрөгийн 14 мэдээллийг шилэн дансны нэгдэн цахим хуудсанд байршуулаагүй байна.	0	Албан шаардлага өгсөн	Дарга, нягтлан бодогч	Б.Бурмаа, Ц.Ган-Өлзий

**Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

4	Тайлант онд тус байгууллагын зочин төлөөлөгч хүлээн авах зардалд 2543.0 мянган төгрөг төлөвлөж хоол бусад зардалд зарцуулсан байна.	2543.0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Б.Бурмаа, Ц.Ган-Өлзий
ДҮН		44217.8			
Цэцэрлэг					
5	Цалин, НДШ-ийн зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримтаас түүн НДШ-ийн тайлантай тулгахад НД-ын байгууллагаас ирүүлсэн НДШ төлөлтийн тайлангаар 81.9 мянган төгрөгийн илүү төлөлттэй байхад авлагаар бүртгээгүй байна.	81.9	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	Т.Болортуяа, М.Түмэнжаргал
6	Өмнөх оны 1429.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүйгээс ХХОАТ-ын тайлангаар 1556.5 мянган төгрөгийн илүү төлөлттэй байна.	1556.5	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	Т.Болортуяа, М.Түмэнжаргал
7	Шилэн дансны сайтад давхардсан тоогоор 149 мэдээллээс байршуулахаас бүтэн жилээр байршуулах 4 төрлийн 4 мэдээлэл, хагас жилээр байршуулах 1 төрлийн 1 мэдээлэл, сараар байршуулах 2 төрлийн 5 мэдээлэл, тухай бүр байршуулах 8 төрлийн 16 мэдээлэл, нийт 26 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба тухай бүр байршуулах 4 төрлийн 4 мэдээллийг огт байршуулаагүй байна.	0	Зөвлөмж өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Т.Болортуяа, М.Түмэнжаргал
ДҮН		1638.4			
Ерөнхий боловсролын сургууль					
8	Тайлант хугацаанд шилэн дансанд 27 төрлийн 151 мэдээлэл байршуулахаас 120 мэдээллийг хугацаанд нь, 22 мэдээллийг хугацаа хоцруулж, 7 мэдээллийг байршуулаагүй байна.	0	Зөвлөмж өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Л.Бумтэрмаа, М.Түмэнжаргал
ДҮН		0			
Сум хөгжүүлэх сан					
9	Шилэн дансны мэдээлэлд 75609.4 мянган төгрөг дутуу мэдээлсэн.	0	Зөвлөмж өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Д.Өлзийбаяр, Г.Алтантуяа
ДҮН		0			
Төсвийн шууд захирагчийн тайлангийн алдааны дүн		45856.2			

---oOo---